

“Нэйшнл лайф” ХХК-д урт хугацааны даатгалын  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 20.1, 20.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Нэйшнл лайф” ХХК-д урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Даатгалын тухай хуулийн 60.1-д заасны дагуу компанийн оноосон нэрэндээ даатгал гэсэн үгийг оруулах, Даатгалын тодорхой хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бүрт Хороонд хандаж зөвшөөрөл авч байхыг “Нэйшнл лайф” ХХК-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, шийдвэрийг Улсын бүртгэлийн алба болон олон нийтэд мэдээлж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ